



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

COMPARATIVE ANALYSIS OF DISASTER RISK MANAGEMENT SYSTEMS

Ц.Цогтбаатар

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн суралцагч

Tsogtbaatar Ts.

Graduate student at the Institute of Management Academy,
the University of Internal Affairs,

*Хариуцлагатай зохиогч: tsoogiitsogtbaatar6@gmail.com

Хураангуй: Аливаа улс орон бусад бүх сегментүүдэд адилхан байдаггүйтэй адил гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь өөр өөр байдаг. Энэхүү өгүүлэлдээ гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үе шатуудад хэрэгжүүлж байгаа чиг үүргийг харьцуулан судлахдаа дөрвөн өөр орныг сонгон авлаа. Үүнд,

Нэгд, улс орны хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг хоёрт, зохион байгуулалтын тогтолцоог судалж, улс орон бүр эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлж, тэдгээрт бэлэн байдлыг хэрхэн нэмэгдүүлж байгааг авч үзсэн.

Судалгааны явцад улс орон бүр эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх асуудлыг нэгдүгээрт, болзошгүй аюулаас хамгаалагдсан байдлыг бүрдүүлэхийн тулд бэлтгэл бэлэн байдлыг хоёрдугаарт, гамшгийн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээ болон үүрэг хариуцлагын хуваарилалт, хариу арга хэмжээний тэргүүлэх чиглэл, бүх түвшний нөөцийг дайчлах, нүүлгэн шилжүүлэх зэрэг асуудлыг гуравдугаарт, сүүлчийн үе шат бол гамшгийн дараа үүсэх үе шат бөгөөд энэ нь түүнийг арилгах үйл явц буюу хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг дөрөвдүгээрт тавьсан байна.

Энэхүү өгүүлэлдээ Монгол Улсын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог судалж, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улс, ОХУ, БНХАУ-ын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж, дээрх улс орнуудын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны давуу талыг гаргаж ирэхийг зорьлоо.

Abstract: The uniqueness of each system stems from the fact that the risks of disasters are specific and that their presence and manifestation are not universal and the same for every country. Just as no country is the same in all other segments, their disaster risk management systems are unequal. The paper describes the systems in four different countries, through observation and comparison of four areas of activity that are implemented in dealing with disasters.

First of all, in the paper, the legal basis and institutional frameworks on which these systems rest in each of the countries were considered – starting from the international level and guidelines given at international conferences, to all by-laws and local disaster activity plans. It was considered how each of the states implements risk mitigation activities and how it increases preparedness for them. When the system recognizes risks, their probability and the frequency of their occurrence, activities are planned to prepare the country and every individual in it for a potentially unwanted event. Differences in the ways of mitigating risks and preparing all elements of the system and protected values for disasters are presented. The third element of action in the event of disasters concerns the response. In this segment, questions are raised regarding institutional solutions in the system, division of responsibilities, the priority of response and mobilization of resources at all levels.

This article aims to study the disaster risk management regulations of Mongolia, scientifically study the disaster risk management systems of the Federal Republic of Germany,

the United States of America, the Russian Federation, and the People's Republic of China, and highlight the advantages of the disaster risk management systems of the above countries.

Түлхүүр үг: гамшгийн эрсдэлийн удирдлага, бууруулах, бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх

Key words: disaster risk management, mitigation, preparedness, response, and recovery

Оршил:

Гамшиг нь улс орнуудын хил хязгаарыг мэддэггүй тул гамшиг тохиолдоход яаралтай хариу арга хэмжээ авахын тулд гамшигт нэрвэгдсэн бүс нутгуудын хооронд түншлэл, хамтын ажиллагааны зохицуулалт байх ёстой болоод байна.

Иймээс үндэсний гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоонд хэрэгжүүлэх эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргээн босгох арга хэмжээний талаар олон улсын

дээд түвшинд зөвшилцөлд хүрэх шаардлага урган гарч байгаа билээ. Улс орон бүр гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хөгжил, боломжид тохируулан олон улсын түвшинд олгогдсон тогтолцоог бий болгож, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө хамтран зохион байгуулалтад ордог.

Дэлхий нийт гамшгаас хамгаалах чиглэлээр нэгдсэн стратегитай болоод 30 гаруй жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд 3 бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлсэн байна.

1994-2005 он	2005-2015 он	2015-2030
Аюул багатай дэлхийн төлөө Йокохамагийн стратеги: Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, гамшгийн аюулыг бууруулах заавар зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	Хёогогийн үйл ажиллагааны хүрээ: Улс үндэстэн, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхыг бий болгох нь	Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ
Байгалийн гамшгийг бууруулах дэлхийн бага хурал, Япон Улсын Йокохама хот, 1994	Гамшгийн аюулыг бууруулах дэлхийн хоёрдугаар бага хурал, Япон Улсын Хёго мужийн Кобе хот, 2005	Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурал, Япон Улсын Мияги мужийн Сендай хот, 2015

Хүснэгт 1., Гамшгийн эрсдэлийн удирдлагын Олон Улсын бодлогын баримт бичиг

НҮБ-аас хүн амын аюулгүй тайван байдлыг хангах, гамшгийн улмаас учирч буй хохирлыг бууруулах зорилгоор анх удаа 1989-1999 оныг “Байгалийн гамшгийн аюулыг бууруулах арван жил” гэж зарласан. Энэ хүрээнд Байгалийн гамшгийн бууруулах дэлхийн бага хурлыг 1994 онд Япон Улсын Йокохама хотноо хийж “Аюул багатай дэлхийн төлөө Йокохама стратеги: байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, гамшгийн аюулыг бууруулах заавар зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан 2005 он хүртэл хэрэгжүүлсэн. Дэлхийн улс орнууд бидний амьдарч буй цаг үе, бүтээн бий болгосон нийгэм нь аливаа аюул, эрсдэлээс

ангид орших боломжгүй тул бид эрсдэл дунд амьдрах шинэ арга замыг олох, байгалийн аюулын нөлөөллийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай, ингэж байж сая бидний хүсэж буй тогтвортой хөгжил хангагдана гэдгийг хүлээн зөвшөөрсөн нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж өгсөн юм. Йокохамагийн стратегийг хэрэгжүүлэх явцдаа дэлхийн улс орнууд байгалийн гамшгийг зогсоож чадахгүй, харин түүний учруулах хор уршгийг багасгах, түүнд өөрсдийгөө бэлтгэх шаардлагатай гэдэг дүгнэлтэд хүрсэн. Улс орнуудын анхаарлыг





МОНГОЛ УЛСЫН ХАМШИГ СУДЛАЛ

байгалийн гамшгийг бууруулахад хандуулсан Йокохамагийн стратеги нь байгалийн аюулын нөлөөллийг бууруулах болон урьдчилан сэргийлэхэд чиглэсэн гамшгаас хамгаалах стратегийг тодорхойлсон анхны баримт бичиг байв

НҮБ-ын Гамшгийн аюулыг бууруулах хоёрдугаар бага хурал 2005 онд Япон Улсын Хёого мужид зохион байгуулагдаж, өмнөх арван жилд хэрэгжүүлсэн Йокохамагийн стратегийг дүгнэн хэлэлцээд дараагийн арван жилд хэрэгжүүлэх “2005-2015 онд авч хэрэгжүүлэх хёогогийн үйл ажиллагааны хүрээ: улс үндэстэн, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхыг бий болгох нь” баримт бичгийг батлан гаргасан. Тус баримт бичгийг хэрэгжүүлснээр “Улс орон, орон нутгийн хэмжээнд гамшгийн улмаас хүний амь нас, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд учрах хохирлыг эрс бууруулах” гэсэн үр дүнд хүрнэ гэж тодорхойлоод дараах таван тэргүүлэх чиглэлийн хүрээнд гамшгийг аюулыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Энэхүү “Хёогогийн үйл ажиллагааны хүрээ: “Улс үндэстэн, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхыг бий болгох нь” баримт бичгийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг анх дэвшүүлэн тавьсан бөгөөд энэхүү баримт бичгийн хэрэгжилт Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Ялангуяа гамшгийн улмаас ядуурлын түвшнийг гүнзгийрүүлэхгүй байхыг чухалчилж үзсэн байдаг. Тус баримт бичиг хэрэгжих хугацаанд ч гамшиг тогтвортой хөгжлийг бий болгох хүчин чармайлтад саад учруулсаар байлаа. Үүний шалтгааныг нь авч үзээд, гамшгийн эрсдэлийг бий болгож буй далд хүчин зүйлс болох уур амьсгалын өөрчлөлт, ядуурал зэргийг шийдвэрлэхгүйгээр тогтвортой хөгжил хангагдах боломжгүй юм гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

НҮБ-аас Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурал Японы Мияги мужийн Сендай хотноо 2015 оны 3 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд

зохион байгуулж, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2005-2015 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ололт амжилт, туршлага, хүндрэл бэрхшээлийг дүгнэсэн. Гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх, учрах хохирлыг багасгах талаар 2005- 2015 онд тодорхой ахиц дэвшил гарсан хэдий ч бүхий л улс орны хүн ам, эд хөрөнгийн гамшигт өртөх байдал нь эмзэг байдлаа бууруулахаас илүү хурдтай нэмэгдэж, гамшгийн шинэ эрсдэлийг бий болгохоос гадна, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, соёл, хүрээлэн буй орчинд богино, дунд, урт хугацаанд ноцтой нөлөөлөн ялангуяа орон нутаг, олон нийтийн түвшинд гамшгийн хохирол улам бүр нэмэгдэж байгааг тоо баримт харуулж байна. Цар хүрээ, эрчимжил багатай гамшиг олон давтан тохиолдож, иргэд, олон нийт, өрх гэр, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд илүүтэй нөлөөлж, нийт хохирлын ихэнх хувийг бүрдүүлж байна. Бүх улс орнууд, нэн ялангуяа гамшгийн улмаас амь насаа алдагсдын тоо, эдийн засгийн хохирлын хэмжээ нь харьцангуй өндөр байдаг хөгжиж буй орнууд санхүүгийн болон хүлээсэн бусад үүргээ биелүүлэхэд ихээхэн хүндрэл, санхүүгийн бэрхшээл, зардал учирч байгааг онцолсон байна. Иймд гамшгийн эрсдэлийг бодитой бууруулахын тулд ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, амьжиргаанд илүүтэй анхаарч, ирэх 15 жилийн хугацаанд “Гамшгийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, ард иргэд, бизнес, олон нийт, улс орны эдийн засаг, нийгэм, биет болон соёлын үнэт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг бодитой бууруулах” үр дүнд хүрэх зорилго тавьж “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийг батлан гаргасан.


Эдгээр бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх явцад гамшиг бол аюулт үзэгдэл, осол ба нийгэм, эдийн засгийн асуудлын нийлбэрийн үр дүн гэдгийг дэлхийн олон оронд тохиолдсон томоохон гамшгийн сургамжууд батлан харуулж, гамшгаас учрах хор уршгийг арилгахаас

илүүтэйгээр гамшгийн эрсдэлийг бууруулах замаар улс орны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн арга хэмжээ авахын ач холбогдлыг хүн төрөлхтөнд ойлгуулсан юм. Иймээс дэлхийн улс орнууд нэгдэн гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, дэлхийн тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр үүрэг, хариуцлага хүлээж, дэлхий нийтээр хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүдийг

батлан, харилцан уялдаатай хэрэгжүүлэх болсон.

Үндсэн хэсэг.

“Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2017)” гэж зааж гамшгийн эрсдэлийг бууруулах тогтолцооны оролцогч талуудыг Засгийн газраас иргэнийг хүртэл тогтоож өгсөн.



Зураг 1. Монгол Улсын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Дээрх зурагт гамшгийн эрсдэлийг бууруулах тогтолцооны оролцогч талууд нь:

- Ерөнхий сайдын удирдлагад ажиллах гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий үндэсний болон орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл;

- Монгол Улсын Шадар сайд чиглүүлж, гамшгаас хамгаалах төрийн бодлого, гамшгаас хамгаалах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг

үүрэгтэй төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага;

- Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг шуурхай зохион байгуулах чиг үүрэг бүхий улсын болон орон нутгийн онцгой комисс;

- Мэргэжлийн дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн захиргааны холбогдох яам, агентлагийг түшиглэсэн улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба;

- Бүх шатны ИТХ, Засаг дарга;

- Аж ахуйн нэгж, байгууллага;

- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага

- Олон нийт, иргэд байна.



МОНГОЛЫН ИРГЭД



ᠬᠤᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

Судалгааны Арга:

Судалгааны зорилго нь Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улс, ОХУ, БНХАУ-ын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог шинжлэх ухааны үндэслэлтэй баримт бичгийг судлах болон харьцуулах аргыг ашиглан тодорхойлохыг зорилоо.

Дээрх асуудлыг судлахад ашигласан харьцуулалт, улс орнуудын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо ямар үндэс суурь дээр тогтсоныг олж мэдэхийн тулд олон улсын түвшинд батлагдсан баримт бичгийг мэдээллийн эх сурвалж болголоо. Түүнчлэн удирдлагын тогтолцоог харьцуулах зорилгоор олон улсын байгууллагын тайлан, шинжлэх ухааны мэргэжлийн сэтгүүл, онолын судалгааны сэдэвтэй холбоотой гадаадын мэдээллийн эх сурвалжыг ашигласан.

Гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны харьцуулсан шинжилгээ:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс:

Гамшгийн эрсдэлийн удирдлагын зохицуулалтын эрх зүйн орчныг авч үзэхдээ Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийг (1949) судлав. Үндсэн хуульд гамшгийн үед холбооны муж, муж хоорондын харилцан туслалцаа үзүүлэх,

гамшгийн үед санхүүгийн тусламж үзүүлэх, түүнчлэн Лисастер зэрэг бүх түвшний төсвийн менежментийг зохицуулахаар тусгасан байна. Түүнчлэн гамшгийн эрсдэлийн чиглэлээр 1999 оноос Гамшгаас урьдчилан сэргийлэх тухай хууль, 1998 оны хууль (Гэрээ) болон 1997 оны Гамшгийн үед иргэний хамгаалалт, тусламж үзүүлэх тухай хуулиуд байна.

ХБНГУ-ын холбооны бүтэц нь гамшгаас хамгаалах үндэсний тогтолцоонд тусгагдсан бөгөөд Холбоо болон холбооны мужуудын хооронд үүрэг хариуцлага хүлээдэг. "Иргэний хамгаалалт" гэдэг нь ерөнхий утгаараа "хүн амыг хамгаалах" юм. Энэ нь цогц ойлголт бөгөөд гамшгаас хамгаалах, иргэний хамгаалалт гэсэн 2 өөр элементээс бүрдэнэ. Үндсэн хуульд зааснаар (1994) Холбооны мужууд энх тайвны үед гамшгийн менежментийг хариуцдаг. Тэд гамшгаас хамгаалах тухай зохих хуулиудыг баталж, бусад зүйлсээс гадна гамшгаас хамгаалах эрх бүхий байгууллагуудыг тодорхойлж, захиргааны болон үйл ажиллагааны хэд хэдэн ажлыг бүс нутаг, орон нутгийн түвшинд шилжүүлсэн байна.

Холбооны бүгд найрамдах Герман улсын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хүснэгт 1-д үзүүлэв.



Хүснэгт 1. ХБНГУ-ын гамшгийн эрсдэлийн удирдлагын бүтэц

Хүснэгтээс харахад ХБНГУ-ын Холбооны Засгийн бүтэц нь гамшгаас хамгаалах үндэсний тогтолцоонд тусгагдсан бөгөөд Холбоо болон холбооны мужуудын хооронд үүрэг хариуцлагын хуваарилалт нь тодорхой туссан байна.

АНУ:

Катрина хар салхины дараа АНУ-ын засгийн газар гамшгаас хамгаалах үндэсний стратегийг бий болгохыг үүрэг болгосон холбооны хууль тогтоомжийг баталсан. FEMA нь NDRF-ийг боловсруулахад тэргүүлж, 2011 оны 9-р сард анхны хэвлэлийг, 2016 оны 6-р сард хоёр дахь хэвлэлийг гаргасан. Үндэсний Холбоо, муж, орон нутаг, овог аймаг, нутаг

дэвсгэрийн харьяаллын дагуу үүрэг, хариуцлага, зохицуулалт, төлөвлөлтийг тодорхойлох замаар үр дүнтэй сэргээх удирдамжийг (2016) шинэчилсэн.

АНУ-ын Америкийн Үндэсний Улаан Загалмай, Авралын Арми болон бусад олон байгууллага зэрэг хувийн сайн дурын байгууллагууд гамшгаас авран туслах үндсэн үүрэг хариуцлагыг хуваарилан зохицуулж, мужийн болон орон нутгийн засаг захиргаа удирдлагаар хангаж байсан байна.

Америкийн Нэгдсэн Улсын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хүснэгт 2-д үзүүлэв.



Хүснэгт 2. АНУ-ын гамшгийн эрсдэлийн удирдлагын бүтэц

Хүснэгтээс харахад Америкийн Нэгдсэн Улсын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны бүтэц нь гамшгаас хамгаалах үндэсний тогтолцоонд тусгагдсан бөгөөд Холбоо болон холбооны мужуудын хооронд үүрэг хариуцлагын хуваарилалт нь тодорхой туссан байна.

ОХУ:

ОХУ-ын гамшгаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах салбарыг хууль ёсны дагуу тогтоож, чиглэлийн зохицуулалтын хувьд хүн ам, нутаг дэвсгэрийг байгалийн болон технологийн гаралтай гамшгаас хамгаалах тухай хууль, иргэний хамгаалалтын тухай хууль, холбооны хэрэгцээг хангах тухай хууль, гамшгийн эсрэг тэмцэх материаллаг хөрөнгийн улсын нөөцийн тухай хуультай.

ОХУ-ын хувьд, Спитакийн газар хөдлөлтөд (1988) олон тооны хүн ам нас барсан ба тухайн үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тогтолцоо тодорхой бус байсан ба үүний улмаас 1990 оны 12 дугаар сарын 27-ны өдөр ОХУ-ын Засгийн газар ОХУ-ын Аврах корпусыг Улсын хороотой зэрэгцүүлэн байгуулж, 1994 онд тус хороог Иргэний хамгаалалт, онцгой байдал, гамшгийн үр дагаврыг арилгах яам (ОХУ-ын EMERKOM) болгон өөрчлөв. Энэхүү Онцгой байдлын яам бол иргэний хамгаалалт, осол, аваар, байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тусгай аврах ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах, хор уршгийг арилгах, ердийн болон бусад зэвсэг хэрэглэх, удирдан






ᠮᠤᠩᠭᠤᠯᠤᠯ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

чиглүүлж, зохицуулалт хийдэг холбооны агентлаг юм.. Иргэний хамгаалалт, онцгой байдал, гамшгийн үр дагаврыг арилгах яам нь ОХУ-ын холбооны эрх баригчид, агентлагууд (бүс нутаг, бүгд найрамдах улсууд), орон нутгийн засаг захиргаатай хамтран ажилладаг. Иргэний хамгаалалт, онцгой байдал, гамшгийн яам нь иргэний хамгаалалтын чиглэлээр иргэн, нутаг дэвсгэрийг байгалийн болон хүний гамшгаас хамгаалах, ус, гал түймрээс

хамгаалах үүрэг бүхий төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих холбооны гүйцэтгэх байгууллага юм.

ОХУ-ын Ерөнхийлөгч нь Иргэний хамгаалалт, онцгой байдал, гамшгийн яамны үйл ажиллагаанд хяналт тавьдаг. (Roffey, 2016)

ОХУ-ын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хүснэгт 3-д үзүүлэв.



Хүснэгт 3. ОХУ-ын гамшгийн эрсдэлийн удирдлагын бүтэц

Гамшгаас хамгаалах төрийн тогтолцоонд ОХУ-ын бүх шатны төрийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, үйл ажиллагаа нь хүн ам, нутаг дэвсгэрийг гамшгаас хамгаалах асуудалтай холбоотой янз бүрийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагууд, түүнчлэн нэгж, байгууламжууд орно. гамшгийн хариу арга хэмжээ авахад шаардлагатай

Салбар хоорондын комисс нь хүн ам, нутаг дэвсгэрийг гамшгаас хамгаалах асуудал хариуцсан дэд сайдын зэрэглэлийн холбооны яамдын төлөөлөгчдөөс бүрддэг. Салбар хоорондын комисс шийдвэр гаргах бүрэн үүрэгтэй. Холбооны болон орон нутгийн түвшинд Комисст харьяалагддаг бүх байгууллагууд Комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Гамшгийн үед хариу арга хэмжээ авах нь тухайн орон нутгийн нэгж эсвэл гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэрт байгаа байгууллага хариуцдаг байхаар зохион байгуулалтад орсон. Арга хэмжээг холбогдох гамшгийн комиссын шууд удирдлага дор гүйцэтгэдэг. Гамшиг нь удирдлагын доод түвшний боломжит хүчнээс давах хэмжээний бол орон нутгийн түвшинд, дээд түвшний комиссоос тусламж хүсэх. Тусламж нь хариу арга хэмжээг зохицуулах эсвэл хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд тусгагдсан байдаг. Үүнээс гадна холбооны дээд түвшинд тусламж хүсч болно. (ОХУ-ын гамшгийн менежмент, 2006).

БНХАУ:

БНХАУ нь 2007 оны 8 дугаар сарын 30-ны өдөр хуралдсан БНХАУ-ын Аравдугаар их хурлын хорооны 29 дүгээр хурлаар "БНХАУ-ын Онцгой байдлын тухай хууль (2007)"-ыг баталж, уг хууль нь гамшгаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдал, хяналт тавих,

эрт сэрэмжлүүлэх, гамшгийн үед аврах ажиллагааг зохион байгуулах, хор уршгийг арилгах, сэргээн босголт, хуулийн хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулдаг. Энэхүү хууль нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бүхий л үе шатанд баримтлахаар тусгасан байна. Үүний зэрэгцээ зөвхөн байгалийн гамшигт үзэгдэл, аюул биш харин осол аваар, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн хамгаалалтай холбоотой осол, нийгмийн ноцтой хохирол учирч болзошгүй бүх гамшгийг хэлж байна. БНХАУ-д гамшгийн цар хүрээг харгалзан гамшиг гэж нэрлэдэг нь хохирлын зэрэг бөгөөд дөрвөн түвшнээр онцгой ноцтой, ноцтой, томоохон, энгийн гэж ялгадаг. Үүнийг харгалзан БНХАУ нь нэгдмэл удирдлага, иж бүрэн зохицуулалт, хамтын удирдлага, тэгш хариуцлага, нутаг дэвсгэрийн удирдлагад суурилсан онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах, удирдах тогтолцоог бий болгосон байна. (БНХАУ-ын Онцгой байдлын тухай хууль, 2007).

НҮБ-ын байгалийн гамшгийг бууруулах олон улсын арван жилийн санаачилгын хариуд Хятадын засгийн газар 1989 онд тус хороог байгуулж, одоо Гамшгийг бууруулах үндэсний хороо гэж нэрлэж байна. Хятадын Төрийн зөвлөлийн яам хоорондын зохицуулалтын механизм болох тус хороо нь гамшгийг бууруулах үндсэн бодлого, төлөвлөгөө боловсруулах үүрэгтэй. 2018 оны 3 дугаар сараас өмнө Иргэний хэргийн яаманд байрлаж байсан комисс одоо Онцгой байдлын яаманд байрладаг (Хятадын Гамшгаас урьдчилан сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа, 2009).


БНХАУ-ын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хүснэгт 4-д үзүүлэв.



МОНГОЛЫН ХУУЛЬ



ᠮᠤᠩᠭᠡᠯᠡᠭᠡᠨ
ᠰᠤᠳᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ



Хүснэгт 4. БНХАУ-ын гамшигийн эрсдэлийн удирдлагын бүтэц

Хятад улс 1998-2010 он хүртэл гамшигийг бууруулах анхны олон жилийн, иж бүрэн үндэсний төлөвлөгөөгөө гаргасан бөгөөд 2007 оноос хойш тус улс гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигийг бууруулах иж бүрэн төлөвлөгөө боловсруулж, засгийн газрын таван жилийн төлөвлөгөөний мөчлөгийг дагаж мөрдөж байна. Эдгээр төлөвлөгөө нь эрсдэлийг бууруулах арга хэмжээг удирдан чиглүүлэх гол түлхүүр болох нь батлагдсан.

БНХАУ Төрийн зөвлөлөөр дамжуулан гамшигийн үед хариу арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлдэг. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төлөвлөгөө байдаг. Төрийн зөвлөлийн яамд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг өөрсдийн чадавхидаа тохируулж, эдгээр төлөвлөгөөг дээд түвшинд төлөвлөгөөтэй уялдуулах ёстой. Энэ нь орон нутгийн захиргаа, муж аймгийн захиргааны хариуцлага болон байгууллага, олон нийтийн оролцоог хангуулна. Орон нутгийн түвшинд хийсэн төлөвлөгөө нь холбогдох бүх хууль тогтоомж, захиргааны дүрэм, дээд түвшний төлөвлөгөөтэй нийцсэн байна. (БНХАУ-ын Онцгой байдлын тухай хууль, 2007).

Дүгнэлт

Гамшиг болсон нутаг дэвсгэрийн тархалт, үргэлжлэх хугацаа, учирч болох үр дагавар, давтамжаасаа шалтгаалан

гамшигийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо өөр өөрийн онцлогтой байна.

Дээрх судалгаанаас харахад улс орон гамшигтай тэмцэх, хариу арга хэмжээ авах, тухайн үед ашиглах нөөцийг нэн тэргүүнд тавьсаар байгаа нь харагдлаа.

Ихнэх улс орон гамшигийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг тэргүүнд тавьж, хүн амд эрсдэл учрахаас сэргийлэх, бууруулах болон өөрсдийгөө хэрхэн хамгаалах талаар мэдлэг олгох үйл ажиллагааг чухалчилж байна.

Дэлхийн бүх улс орон гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тулгуурлан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа ба сүүлийн жилүүдэд даван туулах, дасан зохицох, сөрөн тэсвэрлэх чадавхыг бий болгох ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх явдал юм.

Ингэснээр гамшигт тэсвэртэй байдлыг бий болгохоос гадна эрсдэлийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авснаар урт хугацааны үр өгөөж, ач холбогдлыг мэдэрсээр байна.

ХБНГУ, АНУ, ОХУ, БНХАУ-ыг харьцуулж судлахад улс орон бүр гамшигийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог цаашид бий болгох стандарт, норматив эрх зүйн үндсийг тогтоож, зохицуулсан гэж дүгнэж байна.

Судалгаанд хамрагдсан улс орон бүрийн эрсдэлийг бууруулах нь эрсдэлийг өөрөө, түүний боломжит үр дагаврыг төдийгүй гамшиг тохиолдох үед хийх бүх үйл ажиллагааг сайтар төлөвлөх ёстойг зааж өгсөн байна. Мөн гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулахдаа шатлан туслах зарчмыг баримталдаг.

Герман, АНУ, Орос, Хятад улсуудын хувьд Хиогогийн үйл ажиллагааны хүрээний тэргүүлэх чиглэлүүдийн нэг нь гамшгийн эрсдэлийг бууруулах ажлыг үндэсний болон орон нутгийн түвшинд тэргүүлэх чиглэл болгох хүчин чармайлтыг хүндэтгэж байгааг ажиглаж болно. Муж бүр дээд түвшинд байгуулагдсан байгууллага (зөвлөл, яам, агентлаг, алба) байдаг бөгөөд тэдгээрийн үүрэг нь голчлон гамшгийн үед ажиллах үйл ажиллагааг зохицуулах явдал юм. АНУ-д ийм байгууллага нь судалгаа, боловсрол, сургалт, хариу арга хэмжээ, тусламж болон бусад үйл ажиллагаа эрхэлдэг бол Орос улсад жишээлбэл, гамшгийн үед яам нь төрийн бүх үйлчилгээг хянадаг байна. Тухайлбал, гамшгийн өмнө, гамшгийн үед болон гамшгийн дараа тогтолцоог ажиллуулахын тулд түүнийг бодит нөхцөл байдал, практик үйл ажиллагаанд тохирсон, зохих үндэслэлтэйгээр элементүүд хоорондоо холбогдсон байх ёстой бөгөөд мэдээллийн урсгал, солилцоо нь зохион байгуулалттай байгаа нь ажиглагдлаа. Мөн хариу арга хэмжээ авах үед хариуцлага, чадамжийг тодорхой хуваарилах нь чухал бөгөөд үүнийг норм, нормативаар зохицуулах ёстойг харуулж байна.

Иймд бид дээрх улс орны гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны давуу талыг ашиглах, зөв тогтолцоог нэвтрүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа эрх зүйн зохицуулалт, тэр дундаа норм, нормативыг тодорхой болгож өгөх нь зүйтэй гэж дүгнэж байна.

Эх сурвалжийн жагсаалт:

- Baas, S., Ramasamy, S., DePryck, J. D., & Battista, F. (2008). Disaster Risk Management System Analysis Guide Book. Rome: Food and Agriculture Organisation Of The United Nations.

- Basic Law for the Federal Republic of Germany. (1949). Deutscher Bundestag.

- Building the Resilience of Nations and Communities to Disasters. (18-22 January 2005). World Conference of Disaster Reduction.

- China's Actions for Disaster Prevention and Reduction. (2009, May 11). Retrieved from www.reliefweb.int: <https://reliefweb.int/report/china/full-text-chinas-actions-disaster-prevention-and-reduction>

- Cvetković, V. M., Nikolić, N., Ocal, A., Martinović, J., & Dragašević, A. (2022). A

- Disaster Management in the Russian Federation. (2006). Retrieved from Asian Disaster Reduction Center: <https://www.adrc.asia/management/RUS/Russian.html>

- Disaster Reduction Action Plan of The Peoples Republic of China (2006-2015). (2006). China National Committee for International Disaster Reduction.

- Disaster relief emergency fund (DREF) Russian Federation: Floods . International Red Cross and Red Crescent Societies (2013).

- Domres, B. (2000). The German approach to emergency/disaster management.

- Drabek, T. E., & Evans, J. (2007). Sociology, Disasters and Emergency Management: History, Contributions, and Future Agenda. Department of Sociology and Criminology, University of Denver.

- Emergency Response Law of the People's Republic of China. (2007).

- European Civil Protection and Humanitarian Aid Operations. (2021, August 24). Retrieved from European

- FEMA App: Take Charge of Disasters. (2022, June 30). Retrieved from Ready.gov: <https://www.ready.gov/fema-app>

- Feng, K. (2021, August 17). Plugging the Hole in China's Disaster Recovery Budget. Retrieved from Sixth <https://www.sixthtone.com/news/1008274/plugging-the-hole-in-chinas-disaster-recovery-budget>





МОНГОЛЫН Дотоод Ажлын
Төрийн Газрын
Хууль Сахиулах Удирдлага

- Fuchs, S., Shnyparkov, A., & Jomelli, V. (2017). Editorial to the special issue on natural hazards and risk research in Russia. Springer.

- Ghesquiere, F., Xiao, Y., & Piccio, L. (2020). Learning from experience: Insights from China's progress in disaster risk management. Retrieved from World Bank Blogs:

<https://blogs.worldbank.org/eastasiapacific/learning-experience-insights-chinas-progress-disaster-riskmanagement>

- Global initiative on disaster risk management. (2022, March 14). Retrieved from Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit:

<https://www.giz.de/en/worldwide/40120.html>

- Gurina, R. R., Plyushchikov, V. V., & Kucher, D. E. (1942-1948). International

Engagement of Russian Federation in the Field of Disaster Risk Reduction. International Journal of Civil Engineering and Technology.

- Kiseleva, I. A., Karamanov, M. V., Korotkov, A. V., Kuznetsov, V. I., & Gasparian, M. S. (2018). Risk management in business: concept, types, evaluation criteria. Espacios.

- Yue, C. (2018, August 6). A turning point in China's disaster preparedness? Retrieved from China Dialogue: <https://chinadialogue.net/en/cities/10768-a-turning-point-in-china-s-disaster-preparedness/>

- Zyck, S. A. (2013). Crisis preparedness and response: the Chinese way. Retrieved from <https://odi.org/en/insights/crisis-preparedness-and-response-the-chinese-way>